



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/08.

Сант сум

Малчдын зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.11 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тариалангийн бүс нутагт тохирсон эрчимжсэн мал аж ахуйн суурин, хагас суурин мал аж ахуйд шилжих зорилтыг хэрэгжүүлж мах сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, "Эрчимжсэн мал аж ахуй"-г хөгжүүлэх бодлого чиглэлийг малчдад сурталчлах, цаашдын үйл ажиллагаанд малчдын санал хүсэлтийг тусгах зорилгоор сумын "Малчдын зөвлөгөөн"-ийг 2023 оны 01 дүгээр сарын 26-ний өдөр зохион байгуулсугай.

2. Малчдын зөвлөгөөнийг байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Мөнх-Эрдэнэ

(Засагч даргын орлогч)

Гишүүд: З.Оюунсүрэн

(ХАА-н тасгийн мэргэжилтэн)

Л.Сэлэнгэсайхан

(Ивэн багийн Засаг дарга)

Б.Золбаяр

(Хушаат багийн Засаг дарга)

Г.Анхбаяр

(Тархвар зүйч)

Г.Ууганцэцэг

(Санхүү албаны дарга)

Ч.Азжаргал

(Хууль эрхзүйн мэргэжилтэн)

3. Малчдын зөвлөгөөний хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

4. Зөвлөгөөнд малчдаа бүрэн хамруулж оролцуулахыг багийн Засаг дарга (Л.Сэлэнгэсайхан, Б.Золбаяр) нарт даалгасугай.

5. Малчдын зөвлөгөөнд шаардагдах шатахуун, хүнс болон бусад зардлыг орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн татвараар хийгдэх "Малчдад зориулсан сургалт сурталчилгаа"-ны зардлаас гаргаж санхүүжүүлэхийг сумын

Боловсруулсан: *Б. Оюуншаран*
Хянасан: *Ч. Ахмадгар*
Хувь: *д.*
Огноо: *2022.01.16.*

Санхүү албаны дарга (Г.Ууганцэцэг), Төсвийн нягтлан бодогч (Ч.Мөнхзаяа) нарт зөвшөөрсүгэй.

6.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Одхүү)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

Сэлэнгэ аймгийн Сант сумын Засаг даргын

2023 оны 01 сарын 17-ны өдрийн

A/08 тоот захирамжийн хавсралт

МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨР

Хугацаа: 2023 оны 01 дүгээр сарын 26 –ны / Пүрэв гариг/

Хугацаа	Арга хэмжээний нэр	Хариуцах албан тушаалтан
10.00 -10.30	Оролцогчдыг бүртгэх, соёлын төвд оруулах	Газар тариалан хариуцсан мэргэжилтэн Д.Оюун-Эрдэнэ
Зөвлөгөөнийг нээж үг хэлэх		Засаг дарга С.Шижирбаатар
Үг хэлж мэндчилгээ дэвшүүлнэ		ИТХ-ын дарга Л.Аварга
Урлагийн арга хэмжээ		Соёлын төв
Шагнал гардуулах үйл ажиллагаа		
МАН-н үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, 2022 онд хийж гүйцэтгэсэн ажил 2023 оны зорилт, 2021, 2022 онуудад хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын мэдээлэл, 2023 онд хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөгөө		Засаг дарга С.Шижирбаатар /20 минут/
Сэлэнгэ аймгийн Мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилт		Аймгийн ХХААГ-ын дарга Б.Мөнхтөр /15 минут/
Гоц халдварт өвчин, нөхцөл байдал, анхаарах асуудал		МЭГ-ын дарга С.Ариунтөгс /15 минут/
Малын удмын сангийн үйл ажиллагаа болон малын чанарыг сайжруулах		МУСҮТ-ийн Үйлдвэрлэл хариуцсан захирал Н.Бархас /15 минут/
12.00 -12.10 /Цайны завсарлага/		
2022 оны Малын тоо, толгойн татвар төлөлтийн дүн мэдээ, гадны аймаг сумын зөвшөөрөлгүй отор нүүдэл, хариу арга хэмжээний мэдээлэл, МАН-н өвөлжилтийн бэлтгэл хангалт, аюулгүйн нөөц бүрдүүлэлт		Засаг даргын орлогч Б.Мөнх-Эрдэнэ /15 минут/
Малын паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, туулга хийлгэхийн ач холбогдол		Малын эмч О.Лхагвасүрэн, Ө.Ганбаатар /15 минут/
Бэлчээрийн ерөнхий ойлголт		БОХУБ А.Батдорж /15 минут/
Байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх		Байгаль хамгаалагч Ч.Төгсбаатар /15 минут/
Мэргэжилтнүүдийн зөвлөгөө, сургалтын гарын авлага тараах		ЗДТГ-н мэргэжилтнүүд
Асуулт, хариулт		Малчид, мал бүхий иргэд, мэргэжилтэнгүүд
Санал, хүсэлт		Малчид, мал бүхий иргэд
14.00 - 15.00	Үдийн хоол	ЗДТГ –н мэргэжилтнүүд
Зөвлөгөөнөөс гарах шийдвэрийн төсөл танилцуулах		Засаг дарга

Шийдвэрийн төсөлтэй холбоотой санал асуулга	Малчид, мал бүхий иргэд
Шийдвэрийг хэлэлцэн батлах	Зөвлөгөөнд оролцогсод
Малын эмийн худалдаа	Малын эмч О.Лхагвасүрэн, Ө.Ганбаатар
Иргэдэд анхан шатны эрүүл мэндийн үзлэг, эмийн сангийн үйлчилгээ	ЭМТ
Зөвөлгөөний хаалт	Сумын Засаг дарга
Дурсгалын зураг татуулах	